

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр, Даваа гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 14

- “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2025.03.06-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./*

4 – 14

**Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны
2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 50 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Цогтбаатар, Ж.Алдаржавхлан, Х.Баттулга, Д.Ганбат, Б.Заяабал, Л.Мөнхбаатар, М.Нарантуяа-Нара, Л.Соронзонболд, Б.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Одонтуяа;

Нэг. “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2025.03.06-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын дарга Ч.Нарантуяа, Цагдаагийн ерөнхий газрын дарга Т.Сүхболд, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Ү.Амарбат, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад Цагдаагийн ерөнхий газрын дарга Т.Сүхболд, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Х.Тэмүүжин, С.Эрдэнэболд, П.Сайнзориг нар үг хэлэв.

П.Сайнзориг: “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улсын болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12

75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 24 минут үргэлжилж, 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр 10 цаг 14 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр, Даваа гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
09 цаг 50 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

П.Сайнзориг: Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаан эхэлснийг мэдэгдье.

Хуралдааныг Д.Цогтбаатар дарга санал болгосны дагуу миний биеийг удирдан явуулаач ээ гэсний дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Сайнзориг удирдаж явуулж байна.

Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Сар шинэдээ сайхан шинэлцгээсэн үү.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр Хууль зүйн байнгын хорооны тус өдрийн хуралдаан эхэлж байна. Хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Ирсэн гишүүдээс Норовын Алтанхуяг гишүүн, Энхтайваны Бат-Амгалан, Хүрэлбаатарын Баасанжаргал, Одсүрэнгийн Номинчимэг, Бөхчулууны Пүрэвдорж, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Сүхбаатарын Эрдэнэболд нарын гишүүд ирснээр ирц бүрдсэн байна.

Ингээд Байнгын хороонд хэлэлцэх асуудлыг Та бүгддээ танилцуулъя.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улсын хоорондын хэлэлцээр”-ийн төслийг Засгийн газар 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдөр ирүүлсэн. Зөвшилцөхөөр. Уг асуудлыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор санал хэлэх гишүүд байна уу? Байхгүй юм байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улсын хоорондын хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцье.

Би тайлбарыг өгөх шаардлага байхгүй байх. Тийм ээ. Дэгийн хууль гишүүдэд байгаа учраас.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал танилцуулна. Н.Учрал гишүүний микрофоныг хэлчихье.

Н.Учрал: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын гадаад харилцаа өргөжин хөгжихийн хэрээр иргэдийн гадаадад суралцах, ажиллах болон бизнес, аяллын чиглэлээр харилцан зорчих явдал нэмэгдэж байгааг харгалзан Монголчууд ихээр зорчиж, амьдарч, ажил хөдөлмөр эрхэлдэг улс орнуудтай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ хэлэлцээр байгуулах асуудалд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас анхаарал хандуулан ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг байгуулах саналыг анх Чехийн талаас гаргаж, хэлэлцээрийн төслийг ирүүлсэн бөгөөд манай талаас өөрийн саналыг хүргүүлж, хамтран ажилласнаар талууд хэлэлцээрийн төслийг эцэслэн тохироод байна.

Энэхүү хэлэлцээрийн төсөл нь 5 хэсэг, 29 зүйл, хавсралтаас бүрдэж байгаа бөгөөд хэлэлцэн тохирогч талууд олон нийтийн аюулгүй байдлыг хангаж, нийтийн хэв журмыг сахиулахад зохион байгуулалттай гэмт хэрэгтэй хамтран тэмцэх, урьдчилан сэргийлэх, хоёр улсын эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааны тусгай хэлбэр, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд шалгагдаж байгаа гэмт хэргийн талаар мэдээлэл солилцох, нөгөө талын хүсэлтийг үндэслээд гэмт этгээд гэрч, хохирогчоос тайлбар, мэдүүлэг авах, албан хаагчдыг тодорхой даалгавар гүйцэтгүүлэхээр нөгөө талын нутаг дэвсгэрт томилон ажиллуулах, нууцад хамаарах баримт бичиг болон хүний хувийн мэдээлэл, харилцан солилцох журам, түүнчлэн хамтарсан сургалт, семинар, дадлага, сургууль зохион байгуулах, мэргэжилтнүүдээ бэлтгэх зэрэг харилцааг зохицуулсан.

Уг хэлэлцээрийг байгуулснаар зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, гэмт хэргийн зохион байгуулагчийг олж тогтоох чиглэлд талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх, олон нийтийн аюулгүй байдал, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлд хоёр улсын эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо шууд харилцаж, түргэн шуурхай хамтран ажиллах боломжтой болох юм.

Иймд олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад Улсын Их Хурал эрх зүйн туслалцаа үзүүлэх, гэмт этгээд болон ялтан шилжүүлэхтэй холбогдсон олон улсын гэрээг заавал соёрхон батална гэж

заасны дагуу соёрхон батлах олон улсын гэрээнд хамаарч байх тул олон улсын гэрээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу холбогдох шийдвэрийн төслийг боловсруулан Та бүхэнд танилцуулж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Сайнзориг: Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал, Цагдаагийн ерөнхий газрын дарга Т.Сүхболд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын дарга Ч.Нарантуяа, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг нар оролцож байгаа юм байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор гишүүд Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.7-д асуулт асууж, үг хэлж болно гэж заасны дагуу асуулт асууж, үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя.

Ц.Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Үг, асуулт цуг юм байна шүү. Гишүүн ээ. Ингээд Х.Баасанжаргал гишүүнийг нэмээд 2 гишүүнээр тасалъя. Ц.Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе.

Энэ ганцхан Чех Улс гэж, ер нь манай цагдаагийн байгууллага хоёр улс хоорондын хамтын ажиллагааны чиглэлээр бусад өөр хэчнээн улс оронтой хамтын ажиллагаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ийм хэлэлцээрүүд байна вэ?

Чехэд олон Монголчууд байгаа. Жишээ нь, Солонгос, Япон гээд монголчууд олон байдаг. Америк, Австрали гээд энэ улс орнуудтай хамтын ажиллагаа байна уу, үгүй юу? Нэгд.

Өнгөрсөн хугацаанд энэ Чех Улстай, Чехийн талаасаа хамтын ажиллагаа, хэлэлцээрийг хийе гэсэн санал санаачилгыг гаргасан юм байна.

Цаад тал нь ийм гэрээ хэлэлцээ, санал гаргавал манайх ийм хэлэлцээр байгуулж байна уу, эсвэл манай тал бас бусад улс орнуудад ийм хамтын ажиллагааны чиглэлээр хэлэлцээр байгуулъя гэж санал гаргасан тохиолдол байна уу?

Өнгөрсөн хугацаанд байгуулагдсан хэлэлцээрийн үр дүнг яаж ашиглав? Хэлэлцээрийг. Ямар үр дүн гарав? Хэчнээн иргэний хэчнээн гэмт хэрэгтэй холбоотой асуудлуудаар. Гэмт хэрэгтэй холбогдох асуудлууд.

Одоо энэ Засгийн газрын хэрэгжүүлж байгаа “5Ш” ажиллагаа, авлигатай тэмцэх ажил, энэ чиглэлээр өнгөрсөн хугацаанд хэлэлцээртэй холбоотой асуудал байсан уу? Шилжүүлэх, авчрах асуудлууд байсан уу?

Нөгөө талаар Чех Улсад гэмт хэргийн золиос болж хохирсон манай Монгол Улсын иргэд, хохирогч нар байна уу, үгүй юу? Бүртгэгдсэн асуудлууд байна уу?

Хоёр улсын хооронд ялтан шилжүүлэх асуудал яригдсан уу, хийгдсэн үү, хийгдэж байгаа юу гэх мэтчилэн ийм асуудлууд дээр цагдаагийн байгууллагаас, Хууль зүйн яамнаас холбогдох хариултыг өгөөч.

П.Сайнзориг: Хариултыг Н.Учрал сайд уу эсвэл ажлын хэсгээс үү? Ажлын хэсгийн 4 номерын микрофоныг өгье.

Үг хэлэх тусдаа юм байна шүү. Гишүүд ээ. Би дэгийг андуураад хэлчихсэн байна. Үг хэлж болох юм байна. 4 минутаас илүүгүйгээр. 4 номерын микрофоныг нээе.

Т.Сүхболд: Та бүхний амрыг эрье. Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Цагдаагийн байгууллага нийт 11 оронтой цагдаагийн байгууллага өөрсдөө хамтран ажиллах гэрээтэй ажилладаг. Засгийн газрын түвшинд буюу Хууль зүй, дотоод хэргийн яамны түвшинд цагдаагийн байгууллага 5 оронтой хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллаж байгаа. Энэ нь Орос, Хятад, Турк, Солонгос, Вьетнам улсуудтай шууд хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллаж байгаа.

Цагдаагийн байгууллага хамтран ажиллах гэрээнийхээ хүрээнд 2024 онд 30 гадаадад эрэн сурвалжилж байгаа этгээдийг авчирсан.

Энэ дундаа Европын Холбооны улсаас 17 этгээдийг яг өөрсдөө очиж энэ хамтын ажиллагааныхаа хүрээнд авчирсан.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүднээс энэ хамтран ажиллах гэрээтэй орнууд руугаа цагдаагийн байгууллагад шууд очиж, Монгол Улсын Элчин сайдын яаман дээрээ мөрдөн шалгах ажиллагаа явуулах, гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа этгээдүүдийг тухайн гэрээнийхээ дагуу эрэн сурвалжлуулах, мөн гэмт хэргийн хохирогч болсон иргэдийн алдагдсан эд хөрөнгийг битүүмжлэх, дансанд нь царцаах зэрэг арга хэмжээнүүдийг авсан.

2024 онд Монгол Улсын иргэн хохирсон гэмт хэрэг дээр дансанд нь царцаах арга хэмжээ гэхэд 24 удаа авч ажилласан.

Энэхүү гэрээ нь цагдаагийн байгууллага олон улсын гэрээний хүрээнд анх удаагаа Чех Улсын цагдаагийн байгууллагатай яг холбогдох ажиллагаануудаа бүгдийг нь гэрээ хэлэлцээр дээрээ зааж өгсөн олон улсын гэрээ болж байгаад ач холбогдолтой.

Дээрээс нь энэхүү гэрээгээр эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний дагуу хийгдэж байгаа мөрдөн шалгах ажиллагааг хүлээлгүйгээр цагдаагийн байгууллагын алба хаагч очиж энэ мөрдөн шалгах ажиллагааг явуулах, мөн Европын Холбооны 29 улсад цагдаагийн байгууллагаас мэдээ мэдээлэл, гэмт хэргийн талаар хохирсон иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах зэргээр хамтран ажиллах ач холбогдолтой анхны гэрээ гэж цагдаагийн байгууллагаас үзэж байгаа.

П.Сайнзориг: Хариулт хангалттай юу? Ц.Сандаг-Очир гишүүн ээ. Х.Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Би гэрээний хавсралтаас нэг заалтыг асуугаадахъя. Бараг Н.Учрал сайд хариулах болов уу, яах бол гэж бодож байна.

Нууцын зэрэглэл тогтоосон заалт байгаа. Хавсралт дээр. Манайх нууцад хамааралгүйгээр ирсэн мэдээллийг нөгөө талаас гэсэн үг. Тийм ээ. Нууцад хамааруулахгүйгээр ирсэн мэдээллийг манайх өөрсдөө дандаа нууцын зэрэглэлд авч үзэж хамгаална гэхээр ерөөсөө энэ гэрээний дагуу ирж байгаа бүх мэдээлэл шууд нууцад орж байгаа байхгүй юу.

Тэгэхээр нөгөө талаас нэгэнт нууцад хамааруулахгүй, хязгаарлагдмал хүрээнд, эсвэл захиалсан ч гэдэг юм уу ийм хүрээнд ирж байгаа мэдээллийг манайх яагаад ер нь бүх мэдээллийг дандаа нууцтай хамааруулаад байдаг юм бэ л гэж асуух гэсэн юм.

П.Сайнзориг: Ажлын хэсэг үү? Ажлын хэсгийн хэн хариулах вэ? 3 номер. Нэрээ хэлээрэй. 5 Номер юм уу? Нэр, албан тушаалаа хэлээрэй. Асуултад хариулах даа.

Б.Батзориг: Цагдаагийн Ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, хурандаа Б.Батзориг илтгэж байна.

Гэрээний хавсралтын хүрээнд тухайн улсад нууцын зэрэглэлтэй нууцын зэрэглэлийн түвшин тогтоосон, Монгол Улсад нууцын төслийн түвшин тогтоосон энэ хэмжээнд нууцлах шаардлагатай мэдээ, мэдээлэл, баримтыг нууцална.

Зарим нэг тохиолдол нь нууцын зэрэглэл дээр Монгол Улсын хувьд “нууц”, “маш нууц”, “онц чухал нууц” гэсэн ийм мэдээ мэдээллүүд байгаа. Үндсэндээ энэ агуулга нь гэмт хэрэгтэй тэмцэх, хүний хувийн мэдээлэл хамгаалагдах бусад гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээ, мэдээлэл байгаа бол

дийлэнх нь нууцын зэрэгтэй, агуулгатай нийцэж байгаа юм. Үндсэндээ гэрээний хүрээнд хийгдэж байгаа бүх ажиллагаа тийм байна.

Гэвч хэрвээ нийтэд ил байх шаардлагатай мэдээллүүдийг заавал нууцлах шаардлагагүй. Яг гэрээн дээр юу гэж заасан түүгээрээ л явна гэсэн үг. Хариулт дууслаа.

П.Сайнзориг: Хариулт болсон уу? Гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя.

С.Эрдэнэболд гишүүнээр тасалъя. Н.Алтанхуяг гишүүний микрофоныг өгнө үү.

Н.Алтанхуяг: Монгол Улс Чех Улсын хооронд цагдаагийн байгууллага хамтран ажиллана гэсэн гэрээний төслийг би дэмжиж байна.

Ер нь бид өөрчлөгдөж шинэчлэгдэх ёстой. Тэгэхээр Европын орнууд. Сая 5 оронтой Засгийн газрын түвшинд хамтарч ажилладаг гэж байна шүү дээ.

Тэгэхээр Европын Холбоотой хамтран ажиллах эхлэл нь Чехээр тавигдчихаж байгаа юм. Тэндхийн цагдаагийн байгууллага, тэндхийн мөрдөх бусад бүх төрлийн олон үйл ажиллагаанаас бас дан байдлаараа суралцахад их чухал болох байх.

Мэдээж өөрийнхөө иргэний эрх ашгийг хамгаалах чиглэлд нэлээн сайн ийм зүйл болох байх гэж би горьдож байна.

Би одоо цагдаагийн дарга байсан дээр санал хэлж байгаа учраас нэг юм хэлэх гэсэн юм. Намраас хойш би энэ Сонгинохайрхан дээр хүмүүсээс мөнгө аваад орон сууц бариад. Бариад биш. Барина гэж хэлээд тэгээд тэр нь хэдэн жилээр сунжирсан юм яваад. Сонгинохайрхан дээр би нэлээн ажиллалаа.

Энэ зөвхөн Сонгинохайрханы асуудал биш юм байна. Энэ ерөөсөө бүх нийслэл, улс, аймгууд ямар байдаг юм мэдэхгүй. Нийслэл даяар хамарсан ийм ноцтой асуудал.

Тэгээд би хайгаад явахаар. Цагдаагийн дарга аа. Сонгинохайрхан дээр нэг хэсэг хэрэг. Юу гэдэг билээ. Мөрдөн байцаах газар билүү. Тэнд нэг хэсэг хэрэг гээд. Энд тэнд. Үүнээс болоод. Энэ бол ерөөсөө иргэд яваад ямар ч нэмэргүй шахуу, горьдолтгүй ийм юм бий болсон юм байна.

Яагаад гэхээр тэр дүүрэг хавиар нэг хэсэг уддаг, дараа нь мөрдөн байцаах дээр нь салгаж авдаг. Хаа гуяар нь салгаад энэ ерөөсөө явахгүй юм байна.

Тэгэхээр би ямар санал хэлэх гэж байна вэ гэхээр улсын хэмжээний энэ асуудлыг нэг цэгцэлж, энэ мөнгө төгрөгөөрөө хохирсон маш олон мянган иргэн байгаа юм байна.

Тэгэхээр үүнийг нэг шийдэх гарц шийдлийг манай Байнгын хороо ч гэсэн оролцоод цагдаагийнхантайгаа хамтраад шийдмээр байна. Маш их хэмжээний мөнгө завшиж байна. Цаана нь хөөрхий бараг хашаа байшингаа зараад байранд орё гэсэн хүмүүс хоосон үлдчхээд байна.

Тэгээд эсвэл чи энэ байрнаасаа гарчих. Энэ байран дээр чинь бид байр байр бариад ингээ гэсэн хүмүүс маань байрныхаа түрээсийн мөнгийг төлж эхэлж. Нөгөөдүүл нь төлж явснаа одоо өгөхөө байчихсан. Асар их олон проблем байдаг юм байна.

Би тэгээд яах вэ Хууль зүйн байнгын хорооны гишүүн учраас Цагдаагийн дарга байгаа учраас энэ асуудлыг таны сонорт өгчихье. Би бас тантай нэг цаг аваад уулзаад энэ тухай бүхэлд нь биш, би Сонгинохайрханы тухай ярих гэж байгаа шүү. Баярлалаа.

П.Сайнзориг. Х.Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Ер нь манай цагдаагийн байгууллага хууль сахиулах болон гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагууд барууны хүний эрхийг, хуулийн засаглал руу ойртчихсон хүний эрхийг эрхэмлэдэг энэ улс орнуудтай хамтын гэрээ байгуулах нь зохимжтой бөгөөд илүү соёл солилцох, арга барил сайжрах, хүний эрхийн мэдрэмжтэй болоход их чухал гэж хараад үүнийг дэмжээд байгаа юм.

Тухайлбал, одоо энэ гэрээний 1 дүгээр зүйл дээр ингэж орж ирж байгаа байхгүй юу. “Нийтийн хэв журмыг сахиулах” гэдэг үг. Нөгөө англи болон монгол үгнүүдээ хадаад харахаар манайхан ихэнхдээ юу гээд биччихдэг вэ гэхээр “нийгмийн дэг журам” гэдэг үгээр илэрхийлэх гээд байдаг.

Тэгээд хүний эрх эрх чөлөөг хязгаарлах болон хүний хувийн өмч, өөрийн бие, гэр орон руу халдахдаа энэ зүйлээрээ хэмжүүр болгоод дайрах гэж оролддог.

Гэтэл одоо арай соёлт улс орнуудтай гэрээ хэлцэл хийхээр нөгөөдөх нь “олон нийтийн” буюу “заавал хүн байх ёстой” гэдэг юм шаардаад эхэлж байгаа байхгүй юу. “Нийгэм” гэж хиймэл хоосон, хэмжигдэхэд төвөгтэй тогтолцоо биш “нийтийн” буюу “олон нийтийн хэв хэв журам” гэх мэтчилэн нь олон хүний, хүмүүсийн аюулгүй байдлыг хангах, эсвэл хүнтэй холбоотой асуудлыг шийдэхэд энэ хууль сахиулах LAW ENFORCEMENT хийж байгаа, гэмт хэрэгтэй тэмцэж байгаа чиг үүрэг чинь байгаа шүү гэдгийг тодорхойлох боломжтой болж эхэлж байгаа юм.

Яг үүнтэй адилхан түрүүн Х.Баасанжаргал гишүүн асуулаа. Нөгөө соёлт гэж хэлж болох улсуудад чинь мөрдөн шалгах үйл ажиллагааны нууц гээд бүр хавтгайрсан тийм нууц ерөөсөө байхгүй.

Ямар нууц байна вэ гэхээр хэрвээ гэмт хэргийг илрүүлэх, түүнтэй холбоотой тактик юм уу, эсвэл үйл ажиллагаа нь нууц байгаа бол энэ бол албаны нууц. Албаны нууцыг чинь хадгалах үүрэг бол тэр албанд ажиллаж байгаа юм уу, эсвэл тэр албаны үйл ажиллагааг мэдэж байгаа эрх бүхий этгээдүүдтэй хамаатай болохоос биш хүн болгон руу халдааж хэрэглэж болохгүй зүйл.

Мөрдөн шалгах үйл ажиллагаанд нууцалсан мэдээ баримт гэж байгаа бол тэр чинь шүүхийн анхны хэлэлцүүлэг хүртэл нууцлагддаг. Жишээ нь, нууцалсан гэрч, эсвэл нууц мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд цугласан мэдээлэл гэх мэтчилэн цөөнхөн хэдхэн зүйл байна. Тэр чинь байнгын нууц байхгүй. Шүүх рүү очсоныхоо ар дээр заавал ил болох ёстой. Эсвэл шүүх хаалттай хэлэлцэж байсан ч гэсэн тэр мэдээллийн эх сурвалж чинь нөгөө талдаа ил болж байх ёстой шүү гэдэг шаардлагуудыг тавьж эхэлж байгаа юм.

Тэгэхээр энэ орчин үеийн шаардлагад нийцсэн үг хэллэгээр оруулахгүй бол манайд нууцалдаг юм гээд нууцлах байдлаар явах юм бол бас зовлон үүснэ.

Хоёрт нь, ер нь мөрдөн шалгах үйл ажиллагааны нууцтай холбоотой эрүүгийн хуулийн тэр заалтыг сайжруулах, өөрчлөх шаардлага үнэхээр байгаа юм билээ. Тэгээд тэр чиглэлийн өөрчлөлт орж ирэх байх. Тэр өөрчлөлттэй одоо энэ гэрээний нөхцөл байдал чинь бас зөрчилдөх вийм гэж болгоомжилж хэлж байгаа юм.

П.Сайнзориг: С.Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Баярлалаа. Энэ хэлэлцээрийн яг англи хэл дээрх эх болон монгол орчуулга хоёрын хоорондох тодорхой байдлыг дахиад шалгаж хармаар л юм шиг байна.

Яагаад гэхээр энэ яг Гадаад яамны орчуулга юм уу, эсвэл хаанаас гаргасан орчуулга юм бэ гэж.

Тухайлбал, одоо энэ англи хэл дээрээ CONTRACTING PARTIES гэдгийг манайхаар “хэлэлцэн тохирогч талууд” гэж орчуулсан байх юм. Зарим зүйл дээр бол зүгээр “хэлэлцэгч талууд” гээд.

Тэгээд дээрээс нь INTENTION, AIMING, CONVINCED гэдэг үгүүд дээр бас яг оновчтой орчуулсан эсэх нь жоохон эргэлзээтэй санагдаж байна.

Өөрөөр хэлбэл яг англи хэл дээр байгаа, энэ чинь яг батлагдана гэж ойлгож байгаа. Тэгээд яг ард талд нь нөгөө монгол хэл дээрх орчуулга нь болохоороо хэтэрхий уран сайхны. Эрх зүйн нөгөө түгээмэл нэр томъёон дотор хэрэглэгддэггүй үгүүд явж байгаа байхгүй юу.

Тэгэхээр чинь хоёрдмол утгатай агуулга гарах магадлал байна.

Дараа нь бас тэр. Энэ ядаж “ЕВРОПЫН ХОЛБОО” гэдэг үгээ хоёр янзаар бичсэн. Эм үгийн “ИЙ”-тэй, эр үгийн “Ы”-тэй биччихсэн байх жишээтэй.

Европын Холбоог уг нь дүрмээрээ гадаад үгэнд эм үгийн “ИЙ” ордог. Гэхдээ 2021 оны Токиогийн олимпоос хойш Европын Холбооны гэдгийг эр үгийн “Ы”-ээр бичээд байх жишээтэй.

Тэгэхээр нэг бичиг баримт дээр хоёр янзаар бичсэн үгүүд байна.

Дээрээс нь нэг бичиг баримт дээр яг монгол хэл дээр оновчтой орчуулаагүй байж болзошгүй зүйлс байгаа юм. Энэ нь эцэслэгдээд явах юм бол дахиад үүнийг нэг нягталмаар байгаа юм.

Одоо миний ойлгож байгаагаар энэ чинь 11.00 цагаас дараагийн Байнгын хороогоор хэлэлцэгдээд явна.

Тэгээд үүнээс нь өмнө ч гэдэг юм уу, энэ ажлын хэсгээс орчуулгатай холбоотой зүйлүүдийг нягталмаар байгаа. Учир нь үүнийг чинь дагаад цаашаагаа эрх зүйн үр дагаврууд гарах учраас энэ дээр нягталмаар байна гэж хэлмээр байна.

Тэгээд сүүлийн хэдэн сарын хугацаанд Германд жишээлбэл 2 мянга гаруй хүн баривчлагдсан. Англид нэлээн олон. 3 мянга орчим хүн баривчлагдлаа. Яагаад гэхээр хүний нэр төр, алдар хүндэд халдсан гэдэг асуудал асар эмзэг болоод явчихлаа л даа.

Тэгэхээр энэ 2 дугаар зүйлийн “а” хэсэг дээр жишээлбэл “бусдын амь нас, эрүүл мэнд, эрх чөлөө, алдар хүндийн эсрэг гэмт хэрэг” гээд байлаа гэхэд Монгол дээр энэ Зөрчлийн хуулиар жишээлбэл шийдэгдээд явж байгаа. Гэх мэт. Үүнийг жишээлбэл одоо яг EQUIVALENT буюу хооронд нь холбохдоо нэгэнт Европын Холбооны 27 улсын стандарт юм бол энэ дээр ямар зохицуулалтууд хийх юм бэ ч гэдэг юм уу.

Дээрээс тэр орчуулга дээр жишээлбэл “Европын Холбооны улсуудад гэмт хэрэг үйлдэн Монгол Улсад оргон зайлсан” гээд. Энэ чинь бас хоёрдмол утга агуулаад байгаа байхгүй юу.

“Монгол Улсад оргон зайлсан” гэдэг “Монгол Улс руу оргон зайлсан” гэдгээс ялгаатай юу, үгүй юу гэдэг ч юм уу. “Монгол Улсад үйлдэгдсэн гэмт

хэрэг" дээр тийн ялгал нь “улс руу” буюу одоо нөгөө чиглэхийн тийн ялгал гээд байгаа.

Гэх мэт яг ийм хэл зүйтэй холбоотой зүйлүүд дээр нягталмаар санагдаж байна. Яагаад гэхээр нэг өгүүлбэр дотор хоёрдмол утгатай зүйлүүд байгаа гэдгийг л хэлээд байгаа шүү.

Энэ дээрээ Та бүхэн хууль зүй ETYMOLOGY_[үгийн гарал үүсэл] талаас нь, нэр томъёо талаас нь, найруулга талаас нь дахиад нэг хармаар санагдаж байна. Үүнийг хэлэх гэсэн юм.

П.Сайнзориг: Би нэг үг хэлчихье гэж бодож байна. Тэгээд Н.Алтанхуяг дарга, Х.Тэмүүжин гишүүн, С.Эрдэнэболд гишүүдийн хэлж байгаа саналуудыг анхаараарай.

Хоёрдугаарт, энэ гэрээ одоо их чухал байгаа. Европын Холбооны улсууд. Тэр дундаа мэргэжилтнүүдийг бэлтгэх асуудал дээр яг бодитой төлөвлөгөө гаргаж ажиллаарай.

Түүнээс биш зөвхөн мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд мэдээлэл солилцох, тодорхой ажиллагаануудыг явуулах гэхээсээ илүүтэйгээр боловсон хүчнийг солилцох, бэлтгэх, ялангуяа цагдаагийн байгууллага гэхээсээ илүүтэй бас шүүх шинжилгээний байгууллагын шинжээчдийг бэлтгэх бололцоо ч гэсэн энэ хэлэлцээрийн хүрээнд орж ирж байх шиг байна.

Үүнийгээ илүү их Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам төлөвлөгөөгөө гаргаж, санхүүжилт тавьж, энэ алба хаагчдыг урьдчилан бэлдэж, хэлний шалгуурыг нь хангах нөхцөл байдлыг нь бүрдүүлэхэд онцгой анхаарч бодитой алхам хийгээрэй гэдэг зүйлийг хэлмээр байна.

Тэгээд ер нь тодорхой гэмт хэргүүдийг нэр заасан байгаа дээр анхаарна биз. Бид Европын Холбооны улсуудаас цахим гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд илүү анхаарахыг Хууль зүй, дотоод хэргийн яам, цагдаагийн байгууллагын удирдлагуудаас хүсэж байна.

Ингээд хэлэлцэх асуудалтай холбоотойгоор гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Санал хураалтыг эхэлье. “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улсын болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн томъёолоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Гишүүд саналаа идэвхтэй өгөхийг хүсье. /алх цохив/

Санал хураалтын дүнг танилцуулъя.

75.0 хувийн саналаар зөвшилцөхийг дэмжлээ.

Хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд би танилцуулчихъя.

Өнөөдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Оролцсон Улсын Их Хурлын гишүүд болон ажлын хэсэгт баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 24 минут үргэлжилж, 10 цаг 14 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД